



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/019/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Алтай хот	Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a>
2026 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: <a href="mailto:tserenkhandd@audit.gov.mn">tserenkhandd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Б.Цэвэлмаа
	Утас: 99026016 Цахим хаяг: <a href="mailto:tsevelmaab@audit.gov.mn">tsevelmaab@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>7</b>
<b>3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>12</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>14</b>

---

**Товчилсон үгийн жагсаалт**

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНСС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



### ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13.  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.15 № 151

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Г  
С.ЭНХБАЯР ТАНАА

### Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Шууд бус орлого 41.5 сая төгрөгөөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 6.1 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 5.3 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0.8 сая төгрөгөөр тус тус тасарсан,
- Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт төлөвлөснөөс 10.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон,
- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 187.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 14.3, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалт, Баян-Уул сумын иргэдийн

822511000142

Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 22 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 878 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 2,411.2 сая төгрөгийн иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс чиг үүрэгт хамаарахгүй, хориглосон хөтөлбөр арга хэмжээ буюу урсгал зардал, төсвийн байгууллагын хөрөнгө бэлтгэх, тэтгэмж дэмжлэг, шагнал урамшууллын зардалд 76.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн байгууллагууд 94.9 сая төгрөгийн түлш халаалт, гэрэл цахилгааны өглөгийн үлдэгдэлтэй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд сумын Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 84.3 хувьтай байгааг хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн 71.6 хувийн буюу олонхын саналаар "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,066,517.7	915,538.7
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	407,469.6	344,707.8
3	АВЛАГА	149,360.4	122,034.1
4	БАРАА МАТЕРИАЛ	398,697.5	366,290.7
5	НӨӨЦИЙН БАРАА	34,626.2	34,626.2
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	76,364.0	47,880.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,722,907.1	4,287,222.1
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,722,907.1	4,287,222.1
9	Биет хөрөнгө	1,660,379.1	4,222,339.9
10	Биет бус хөрөнгө	62,528.0	64,882.2
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,789,424.7	5,202,760.9
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,961.5	148,766.1
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,961.5	148,766.1
14	Өглөг	8,961.5	148,766.1
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,780,463.2	5,053,994.8
16	Засгийн газрын хувь оролцоо	2,780,463.2	5,053,994.8
17	Засгийн газрын оруулсан капитал	300,508.7	300,508.7
18	Хуримтлагдсан үр	2,471,958.3	4,745,489.9
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,996.3	7,996.3
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,789,424.7	5,202,760.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,647,343.5	4,983,916.1
2	ТАТВАРЫН ОРЛОГО	627,720.9	642,182.7
3	Орлогын албан татвар	543,046.0	496,855.9
4	Хувь хүний орлогын албан татвар	565,359.1	547,954.5
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(22,313.1)	(51,098.5)
6	Хөрөнгийн албан татвар	75,707.2	127,294.4
7	Бусад татвар, төлбөр, хураамж	8,967.7	18,032.3
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	659,221.6	4,341,733.5
9	Тусламжийн орлого	0.0	1,338,490.7
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,360,401.0	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,721,274.1	2,702,570.8
12	УРСГАЛ ЗАРДАЛ	2,721,274.1	2,702,570.8
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,659,632.4	2,701,070.8
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	760,914.7	833,064.1
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,252.7	108,240.7
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	861,142.6	947,885.9
17	Хангамж, бараа материалын зардал	62,365.6	70,300.6
18	Нормативт зардал	800.0	1,190.0

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

19	Эд хогшил, урсгал засварын зардал	449,802.5	29,570.0
20	Томилолт, зочны зардал	28,236.0	16,546.0
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,950.5	354,002.3
22	Бараа үйлчилгээний бусад зардал	360,167.7	340,271.3
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,641.7	1,500.0
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	926,069.4	2,281,345.3
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	396,745.7	7,813.8
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(396,745.7)	(7,813.8)
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	529,323.7	2,273,531.6

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,256,452.8	2,256,452.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(5,313.2)	(5,313.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,251,139.6	2,251,139.6
4	Тайлант үеийн үр дүн	529,323.7	529,323.7
5	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,780,463.2	2,780,463.2
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,780,463.2	2,780,463.2
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,780,463.2	2,780,463.2
8	Тайлант үеийн үр дүн	2,273,531.6	2,273,531.6
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,053,994.8	5,053,994.8

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,042,245.7	2,314,322.2
2	ТАТВАРЫН ОРЛОГО	627,720.9	644,882.7
3	Орлогын албан татвар	543,046.0	496,854.9
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(22,313.1)	(51,098.51)
5	Хөрөнгийн албан татвар	75,707.2	127,294.4
6	Бусад татвар, төлбөр, хураамж	8,967.7	20,733.3
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,817.2	4,927.3
8	Газрын төлбөр	6,150.5	12,946.0
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	2,860.0
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,123.8	1,669,439.5
11	Нийтлэг татварын бус орлого	54,123.8	71,939.7
12	Тусламжийн орлого	-	1,338,490.7
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	259,009.2
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,360,401.0	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,409,457.4	1,961,343.8
16	УРСГАЛ ЗАРДАЛ	2,409,457.4	1,961,343.8

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,347,815.7	1,959,843.8
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	757,174.2	841,460.8
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,335.8	105,020.7
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	861,142.6	852,973.3
21	Хангамж, бараа материалын зардал	50,916.6	28,813.9
22	Нормативт зардал	800.0	-
23	Эд хогшил, урсгал засварын зардал	397,366.7	31,112.3
24	Томилолт, зочны зардал	28,236.0	17,736.0
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,950.5	59,206.1
26	Бараа үйлчилгээний бусад зардал	110,893.2	23,520.7
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,641.7	1,500.0
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	632,788.4	352,978.4
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	481,178.1	415,740.1
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	481,178.1	415,740.1
31	Дотоод эх үүсвэрээр	481,178.1	415,740.1
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(481,178.1)	(415,740.1)
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	151,610.3	(62,761.8)
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	255,859.3	407,469.6
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	407,469.6	344,707.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,564,575.2	2,308,106.6	256,468.6	90.0
11	Татварын орлого	633,488.1	644,882.6	(11,394.5)	101.8
110	Орлогын албан татвар	530,997.7	496,854.9	34,142.8	93.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	582,096.2	547,953.4	34,142.8	94.1
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	406,637.4	400,561.5	6,075.9	98.5
110002	Үйл ажиллагааны орлого	7,000.0	10,008.1	(3,008.1)	143.0
110003	Хөрөнгийн орлого	71,243.5	82,485.7	(11,242.2)	115.8
110004	Хөрөнгө борлуулсны орлого	794.0	-	794.0	-
110008	Шууд бус орлого	96,421.3	54,898.2	41,523.1	56.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(51,098.5)	(51,098.5)	0.0	100.0
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(51,098.5)	(51,098.5)	0.0	100.0
113	Хөрөнгийн албан татвар	92,800.0	127,294.4	(34,494.4)	137.2
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	7,200.0	1,863.6	5,336.4	25.9
113002	Бууны албан татвар	1,600.0	2,928.6	(1,328.6)	183.0
113004	Малд ногдуулах албан татвар	84,000.0	122,502.2	(38,502.2)	145.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	9,690.4	20,733.3	(11,042.9)	214.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,600.0	4,927.3	(2,327.3)	189.5
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,600.0	4,374.8	(1,774.8)	168.3
118011	Бусад татвар	-	552.5	(552.5)	
1181	Газрын төлбөр	7,090.4	12,946.0	(5,855.6)	182.6
118101	Газрын төлбөр	6,800.0	9,407.3	(2,607.3)	138.3

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

118102	Дуудлага худалдаа	290.4	3,538.7	(3,248.3)	1,218.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	2,860.0	(2,860.0)	
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	160.0	(160.0)	
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	2,700.0	(2,700.0)	
12	Татварын бус орлого	1,637,400.5	1,663,223.9	(25,823.4)	101.6
120	Нийтлэг татварын бус орлого	43,500.0	71,939.7	(28,439.7)	165.4
120003	Торгуулийн орлого	6,500.0	6,854.0	(354.0)	105.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	37,000.0	49,684.0	(12,684.0)	134.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	15,401.7	(15,401.7)	
122	Тусламжийн орлого	1,332,275.1	1,332,275.1	-	100.0
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,332,275.1	1,332,275.1	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	-	-	-	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	261,625.4	259,009.1	2,616.3	99.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	261,625.4	259,009.1	2,616.3	99.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	293,686.6	-	293,686.6	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,564,575.2	2,286,746.6	277,828.6	89.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,009,274.9	1,913,555.5	95,719.4	95.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,007,774.9	1,912,055.5	95,719.4	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	849,187.2	841,460.8	7,726.4	99.1
210101	Үндсэн цалин	306,788.0	373,073.9	(66,285.9)	121.6
210102	Нэмэгдэл	542,399.2	468,386.9	74,012.3	86.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,148.4	105,020.7	1,127.7	98.9
210201	Тэтгэврийн даатгал	72,541.0	71,851.0	690.0	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,401.9	8,300.3	101.6	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,200.9	4,189.1	11.8	99.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,200.9	4,095.5	105.4	97.5
210205	Эрүүл мэндийн даатгал	16,803.7	16,584.9	218.8	98.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	861,218.3	852,973.3	8,245.0	99.0
210301	Гэрэл, цахилгаан	35,958.9	31,631.3	4,327.6	88.0
210302	Түлш, халаалт	824,321.6	821,045.1	3,276.5	99.6
210303	Цэвэр, бохир ус	937.8	297.0	640.8	31.7
2104	Хангамж, бараа материалын зардал	40,625.0	27,433.7	13,191.3	67.5
210401	Бичиг хэрэг	4,000.0	3,644.8	355.2	91.1
210402	Тээвэр, шатахуун	29,600.0	18,114.7	11,485.3	61.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,525.0	1,514.7	1,010.3	60.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500.0	1,500.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000.0	2,659.5	340.5	88.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,500.0	31,112.3	16,387.7	65.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500.0	-	2,500.0	-

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210604	Урсгал засвар	45,000.0	31,112.3	13,887.7	69.1
2107	Томилолт, зочны зардал	19,316.3	17,736.0	1,580.3	91.8
210702	Дотоод албан томилолт	19,316.3	17,736.0	1,580.3	91.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,979.7	22,176.1	41,803.6	34.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,540.0	20,770.0	41,770.0	33.2
210803	Даатгалын үйлчилгээ	400.0	400.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129.7	129.8	(0.1)	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200.0	200.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460.0	440.0	20.0	95.7
210807	Газрын төлбөр	250.0	236.4	13.6	94.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,800.0	14,142.5	5,657.5	71.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000.0	12,945.1	5,054.9	71.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800.0	1,197.4	602.6	66.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500.0	1,500.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500.0	1,500.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500.0	1,500.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	455,300.3	373,191.1	82,109.2	82.0
223001	Бусад хөрөнгө	455,300.3	373,191.1	82,109.2	82.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	311,969.5		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	333,329.5		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	104,411,637.0
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,411,637.0
3	122	Тусламжийн орлого	104,411,637.0
4	1221	Хандив тусламж /дотоод/	104,411,637.0
5	12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,411,637.0
6	350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,166,637.0
7	350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	245,000.0
8	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	93,784,875.0
9	21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,784,875.0
10	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,784,875.0
11	2104	Хангамж, бараа материалын зардал	1,380,178.0
12	210401	Бичиг хэрэг	235,250.0
13	210402	Тээвэр, шатахуун	924,928.0
14	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.0
15	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,000.0
16	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,579,000.0
17	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,579,000.0

18	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,825,697.0
19	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,825,697.0
20	4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	10,626,762.0
21	5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(10,626,762.0)
22	6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(10,626,762.0)

### 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 3.1.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллага, аудит хийсэн хэлбэр

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (ЕБС, Соёлын төв, Цэцэрлэг, ЭМТ) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн, ИТХ, ХХС, БХНСС, ОНХС, Соёлын төвийг санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж түүвэрт хамруулан, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаас тогтмол зардлыг аудитад хамруулсан.

Нийт залруулагдаагүй 187.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 22.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 126.5 сая төгрөгийн зөрчилд 7 заалт зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна

#### 3.1.2 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 4.8 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 88.8 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлснээс 38.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 50.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

#### 3.1.3 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 144.5 сая төгрөгийн 5 алдаа, мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой 118.7 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 99.0 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 22.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 76.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Залруулагдаагүй нийт 64.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 28.0 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 64.5 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс зөрчил арилгах 1 албан шаардлага, 64.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

### 3.3 Албан шаардлага

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 188.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 22.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 38.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 126.5 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх

асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Батлагдсан төсөв, орлого, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 6.1 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0.8 сая төгрөгөөр, шууд бус орлого 41.5 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 5.3 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 22 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах

Илрүүлэлт: Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт төлөвлөснөөс 10.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 22 дугаар тогтоолыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Баян-Уул сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баян-Уул сумын ЗДТГ	3	4,798.6	-	-	3	4,798.6	3	4,798.6	-	-	-	-
Баян-Уул сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баян-Уул сумын ОНХС	4	233,394.0	1	91,626.0	3	141,768.0	4	233,394.0	-	-	-	-
Баян-Уул сумын БХНСС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баян-Уул сумын ХХС	3	29,762.7	1	27,041.3	2	2,721.4	3	29,762.7	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>267,955.3</b>	<b>2</b>	<b>118,667.3</b>	<b>8</b>	<b>149,288.0</b>	<b>10</b>	<b>267,955.3</b>	-	-	-	-

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Баян-Уул сумын Засаг дарга	2	64,494.5	-	-	-	-	2	64,494.5	-	-	-	-
Баян-Уул сумын ЗДТГ	6	88,813.0	-	-	2	38,815.3	4	49,997.7	-	-	-	-
Баян-Уул сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баян-Уул сумын ОНХС	3	76,549.4	-	-	-	-	3	76,549.4	-	-	-	-
Баян-Уул сумын БХНСС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баян-Уул сумын ХХС	1	22,529.0	1	22,529.0	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>252,385.9</b>	<b>1</b>	<b>22,529.0</b>	<b>2</b>	<b>38,815.3</b>	<b>9</b>	<b>191,041.6</b>	-	-	-	-

4.3 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Баян-Уул сумын Засаг дарга	1	1	-	-	-	1	-	-
2	Баян-Уул сумын ЗДТГ	1	1	-	-	1	-	-	-
3	Баян-Уул сумын ИТХ	1	-	1	-	-	-	-	-
4	Баян-Уул сумын ОНХС	1	-	1	-	-	-	-	-
5	Баян-Уул сумын БХНСС	1	-	1	-	-	-	-	-
6	Баян-Уул сумын ХХС	1	-	1	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>